



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/43

Эмээлтөлгой

Ой хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.12, Улсын Онцгой Комиссын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай" 02 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/117 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1.Сумын хэмжээнд ой хээрийн түймэр гарах эрсдэл бүхий нутагт хуурайшилтын үед ойд хориглосон үйл ажиллагаа, ойн дагалт баялаг ашиглах, бугын эвэр түүхийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд түр хориглосугай.

2.Ой хээрийн гал түймэр гарах эрсдэлтэй тухайн хугацаанд урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, эргүүл, харуул ажиллуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, малчин айл өрх, иргэд, идэвхтэн, байгаль хамгаалагч нарыг хамтран ажиллахыг Байгаль орчны ажлын алба, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХЖАРГАЛ



842401071

ДАРГА  БАТЛАВ
..... оны дугаар сарын өдөр
Д.МӨНХЖАРГАЛ

ЖАРГАЛАНТ СУМАНД ОЙ ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТАЛААР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 03 дугаар сарын 28

Эмээл толгой

Д/д	Хийж хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар захирамж гаргуулан ажлын хэсэг байгуулан, хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллах	2024.03.22-2024.03.28	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар
2.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Бугын эвэр түүж бэлтгэх үйл ажиллагаа, ойн санд хохирол учрахаас сэргийлэн хяналт шалгалтыг эрчимжүүлэх	2024.04.01-2024.06.10	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар
3.	Ой хээрийн болон гал түймэр унтраах шаардлагатай багаж хэрэгслийг бэлэн байлгах, бүрэн бүтэн байдлыг хангуулах	2024.04.01-2024.04.15	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар
4.	Ерөнхий боловсролын сурагчдад Эко бүлгийн сурагчдаар дамжуулан "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай" мэдээлэл, сургалт зохион байгуулах	2024.04.01-2024.05.10	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар
5.	"Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай" аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/117 дугаартай захирамж, сумын Засаг даргын захирамжийг малчид, иргэдэд сурталчлан ажиллах	2024.04.01-2024.06.10	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар
6.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх гарын авлага, сэрэмжлүүлэг, мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэх	2024.04.01-2024.06.10	БОХУБ, Байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ Ж.СҮХБААТАР